



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2013 оны 5 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$4,111 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 4,111 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар буюу 236 сая ам.доллараар буурчээ. Үүнд экспорт 56 сая ам.доллараар, импорт 180 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Жилийн өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үеэс 11 нэгж хувиар буурсан бөгөөд үүнд экспортын жилийн өсөлт 6 нэгж хувиар, импортын жилийн өсөлт 17 нэгж хувиар буурсан нь нөлөөлжээ.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 49% буюу 1,995 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 15% буюу 601 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 22%-иар тус тус буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$825 сая

Мөнгөн дүн 2013 оны эхний 5 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -825 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 13%-иар буюу 124 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 3%-иар, импорт 7%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл 2012 оны 9 дүгээр сараас аажмаар багассаар тайлант хугацааны эцэст экспорт нь импортоос 1%-ийн илүү бууралттай гарсан байна. Дүрслэл 1-ээс харахад экспорт, импортын жилийн өсөлтийн хурд 2011 оны 10 дугаар сараас хойш буурсан хэвээр байгаа бөгөөд 2013 оны 5 дугаар сард өмнөх сараас бага зэрэг өсчээ.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: -\$625 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм.

Энэхүү үзүүлэлт 2013 оны эхний 5 сард -625 сая ам.долларт хүрч, худалдааны нийт дүн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.7%-иар буурчээ. Үүнд валютын төлбөртэй импортын дүн 1.0%-иар өссөн ч экспортын дүн 4.8 нэгж хувиар их буюу 3.8%-иар буурсан нь нөлөөлөв.


Гадаад худалдааны нөхцөл: 1.429

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.429-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.7%-иар буурлаа. Үүнд нефтийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн орцын импортын өсөлт болон зэсийн баяжмал, нүүрсний экспортын бууралт голлон нөлөөлжээ.


Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 5 сар			Өөрчлөлт			
	2013	2012	2011	2013/2012		2012/2011	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	4,111.3	4,347.0	3,695.6	(235.7)	-5%	651.4	18%
Экспорт	1,643.3	1,699.0	1,578.0	(55.7)	-3%	121.0	8%
Импорт	2,468.1	2,648.0	2,117.6	(179.9)	-7%	530.4	25%
Тэнцэл	(824.8)	(949.0)	(539.5)	124.2	-13%	(409.5)	1.8x


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт



Бүтэц: 88%+ 12%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар буурч нийт экспортын 88%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 84%, нийт экспортын 74%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 7 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 10 нэгж хувиар буурсан байна.

Өсөлт: -3.3%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 3.3%-иар буурсан бөгөөд уг бууралт нь ашигт малтмалын экспортын 7%-ийн бууралтаар тайлбарлагдаж байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл төмрийн хүдэр ба баяжмал, мөнгөжөөгүй алтны экспортын өсөлтүүд нь уг бүлгийн өсөлтийн 12%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 43%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 22%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж нийт экспорт 90 сая ам.доллараар өсөхөөр байсан боловч, үнийн бууралтаас шалтгаалж 145 сая ам.доллараар буурсанаар нийтдээ 56 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд боловсруулаагүй нефть, цайрын хүдэр ба баяжмал, мөнгөжөөгүй алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 163 сая ам.доллараар өсөхөөр байсан боловч чулуун нүүрс, төмрийн хүдэр ба баяжмал, жонш, лейцит, нефелитийн экспортын тоо хэмжээ буурсанаас, мөн нүүрс, боловсруулаагүй нефть, мөнгөжөөгүй алтны үнийн дүн буурсанаас шалтгаалж нийт ашигт малтмалын экспорт 112 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүн болон бусад экспортын хувьд үнийн дүн болон тоо хэмжээ зэрэг өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 13 сая болон 22 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2013 оны 5 дүгээр сарын 31-ний байдлаар унц тутамд 1,387.8 хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 11.1%-иар, өмнөх сараас 6.0%-иар тус тус буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2013 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар 7,280.8, 1,893.8 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 2.1%-иар буурч, 1.5%-иар өссөн, өмнөх сараас 3.7%, 3.2%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2013			2012			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мйн.тн,кг)	Дүн	%	Тоо/хэм (мйн.тн,кг)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал		1,451	88%		1,563	92%	(112)	↓ -7%	-7%
Чулуун нүүрс	6,332	449	27%	7,268	793	47%	(345)	↓ -43%	-22%
Зэсийн баяжмал	232	338	2%	231	339	20%	(2)	↓ 0%	0%
Төмрийн хүдэр/баяж.	2,324	262	16%	2,387	168	10%	94	↑ 56%	6%
Боловсруулаагүй нефть	1,789	169	10%	1,262	127	7%	42	↑ 33%	3%
Цайрын хүдэр ба баяж.	69	67	4%	49	48	3%	19	↑ 40%	1%
Мөнгөжөөгүй алт	2,959	126	8%	889	39	2%	87	↑ 225%	6%
Жонш, лейцит, нефелит	108	26	2%	154	33	2%	(7)	↓ -22%	0%
Молибдений хүдэр/баяж	2	14	1%	2	15	1%	(2)	↓ -12%	0%
2. Ноос, ноолуур		105.5	6%		70.8	4%	35	↑ 49%	2%
Ямааны уга.ноолуу ур	1957	93	6%	1444	59	3%	33.5	↑ 56%	47%
Ямааны сам.ноолуу ур	134	13	1%	125	11	1%	12	↑ 10%	2%
3. Бусад		87	5%		65	4%	22	↑ 34%	1%
Нийт дүн		1,643			1,699		(55.7)	↓ -3.3%	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	47		(159)		(112)	
Чулуун нүүрс	(102)	30%	(242)	70%	(345)	61%
Зэсийн баяжмал	1	-57%	(2)	157%	(2)	3%
Төмрийн хүдэр ба баяжмал	(4)	-5%	99	105%	94	-16%
Боловсруулаагүй нефть	53	126%	(1)	-26%	42	-76%
Цайрын хүдэр ба баяжмал	20	103%	(1)	-3%	19	-34%
Мөнгөжөөгүй алт	90	104%	(3)	-4%	87	-15%
Жонш, лейцит, нефелит	(1)	136%	3	-36%	(7)	13%
Молибдений хүдэр ба баяжмал	(1)	50%	(1)	50%	(2)	3%
2. Ноос, ноолуур	22		13		35	
Ямааны угаасан ноолуу ур	211	63%	12.4	37%	33.5	-60%
Ямааны самнасан ноолуу ур	0.9	74%	0.3	26%	12	-2%
3. Бусад	21	97%	1	3%	22	-39%
Нийт	89.6		(145.4)		(55.7)	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнэ



Бүтэц: 27% + 21%

2013 оны эхний 5 сарын байдлаар нийт импортын 48%-ийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 12%-ийг өргөн хэрэглээ, 3%-ийг хүнсний бараа, үлдсэн 37%-ийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын нийт импортод эзлэх хувь хувь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар буурсан нь нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өөрчлөгдөөгүй ч үйлдвэрлэлийн орцын хувийн жин 2 нэгж хувиар буурсантай холбоотой байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь өөрчлөлт багатай, тогтвортой хэвээр байна.

Өсөлт: -7%

Импортын 7%-ийн бууралтыг ерөнхий ангиллаар задалвал үйлдвэрлэлийн орцын бууралт нь 3%-ийг, нефтийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний импорт, бусад бүтээгдэхүүний импортын бууралт нь тус бүр 1%-ийг тайлбарлаж байна.

Үйлдвэрлэлийн орц өмнөх оноос 11%-иар буюу 86 сая ам.доллараар, өргөн хэрэглээний импорт өмнөх оноос 11%-иар буюу 37 сая ам.доллараар буурсан нь нийт импортыг 7%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Өөрчлөлт

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импорт нь тоо хэмжээний бууралтаас шалтгаалан 143 сая ам.доллараар, үнийн дүнгийн бууралтаас шалтгаалан 37 сая ам.доллараар, нийт дүнгээр 180 сая ам.доллараар буурчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импортын 20 сая ам.долларын бууралтын 21 сая ам.доллар нь тоо хэмжээний бууралтаас шалтгаалсан бол хилийн үнийн өсөлттэй холбоотойгоор үнийн дүн нь 0.9 сая ам.доллараар өссөн байна. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2012 оны эхнээс буурч, 8 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны 1 дүгээр сараас эхлэн буцаад буурч байна.

Үйлдвэрлэлийн орцын бууралтын 93% нь тоо хэмжээний, 7% нь үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж нийт дүнгээр 86 сая ам.доллараар буурсан байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 72% нь тоо хэмжээний, 28% нь үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж 37 сая ам.доллараар буурчээ.

Зарим хэрэглээний барааны импорт*

Голлох хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст – 6%-д хүрч буурсан байна.

Цахилгаан барааны жилийн өсөлтийн хувьд 2010 оны эхнээс 2011 оны дунд үе хүртэл өсөөд байсан ч 2012 оны 6 дугаар сараас хойш буурсаар байна. Харин суудлын автомашины импортын өсөлт жилийн өсөлтийн түвшин 2011 оны эхнээс буурч байсан бол тайлант хугацаанд өнгөрсөн оны мөн үетэй тэнцүү хэмжээнд хүрчээ.

*Нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцоолов.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2013			2012			Өөрчлөлт		
	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2
Үйлдвэрлэлийн орц		669	27%		755	29%	(86)	-11%	-3%
Хүнд механизм, тоног төх.	4,660	383	57%	4,411	449	60%	(66)	-15%	-9%
Суудлаас бусад автомашин	390	234	35%	399	248	33%	(14)	-6%	-2%
Төмөр хийц, металл бүт.	12,001	17	3%	13,891	21	3%	(4)	-19%	-1%
Бусад бүтээгдэхүүн	211,305	35	5%	44,740	36	5%	(2)	-5%	0%
Нефть		530	21%		551	21%	(20)	-4%	-1%
Дизель түлш	262,770	314	59%	283,593	336	61%	(22)	-7%	-4%
АИ-92, АИ-95	92,907	115	22%	97,484	122	22%	(8)	-6%	-1%
А-80 болон бусад	79,430	102	19%	71,863	92	17%	10	11%	2%
Өргөн хэрэглээ		293	12%		331	12%	(37)	-11%	-1%
Суудлын автомашин	19	156	53%	18	185	56%	(29)	-16%	-9%
Цахилгаан бараа	459	64	22%	432	67	20%	(3)	-5%	-1%
Бүх төрлийн эм	769	26	9%	721	30	9%	(4)	-14%	-1%
Бусад өргөн хэрэглээний	6,304	48	16%	5,842	48	15%	(1)	-2%	0%
Хүнс		66	3%		72	3%	(6)	-9%	0%
Гурил, будаа, талх	18,833	19	28%	43,710	24	33%	(5)	-21%	-7%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	2,214	8	12%	2,417	9	13%	(2)	-20%	-3%
Төрөл бүрийн өөх тос	9,674	13	19%	9,081	12	17%	1	4%	1%
Согтууруулах ундаа	9,387	8	12%	8,872	8	11%	0	0%	0%
Хүнсний ногоо	29,707	6	9%	32,779	6	8%	(0)	-1%	0%
Бусад	24,692	13	20%	22,930	13	18%	0	1%	0%
Бусад импорт		910	37%		939	35%	(30)	-3%	-1%
Бусад	910			939			(30)	-3%	-3%
Нийт дүн		2,468			2,648		(180)	-7%	-7%

*2 - Өсөлтөө оруулсан хувь юм (contribution to the growth)

Дүрслэл 6. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Хүснэгт 5. Импортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Эзлэх хувь	Үнийн дүнгийн өөрчлөлт		Эзлэх хувь	Нийт өөрчлөлт		Эзлэх хувь
	(80.3)	93%		(6.0)	7%		(86.3)		
Үйлдвэрлэлийн орц	(80.3)	93%		(6.0)	7%		(86.3)		
Хүнд механизм, тоног төх.	(57.8)	87%		(8.6)	13%		(66.4)	77%	
Суудлаас бусад автомашин	(17.5)	125%		3.5	-25%		(14.1)	16%	
Төмөр хийц, металл бүт.	(4.4)	111%		0.4	-11%		(4.0)	5%	
Бусад бүтээгдэхүүн	(0.6)	34%		(1.2)	66%		(1.9)	2%	
Нефть	(21.3)	104%		0.9	-4%		(20.4)		
Дизель түлш	(24.7)	110%		2.3	-10%		(22.4)	110%	
АИ-92, АИ-95	(5.7)	74%		(2.0)	26%		(7.7)	38%	
А-80 болон бусад	9.2	94%		0.6	6%		9.8	-48%	
Өргөн хэрэглээ	(27.0)	72%		(10.4)	28%		(37.4)		
Суудлын автомашин	(18.9)	65%		(10.1)	35%		(28.9)	77%	
Цахилгаан бараа	(2.5)	76%		(0.8)	24%		(3.3)	9%	
Бүх төрлийн эм	(4.9)	113%		0.6	-13%		(4.3)	11%	
Бусад өргөн хэрэглээний	(0.8)	89%		(0.1)	11%		(0.9)	2%	
Хүнс	(4.6)	74%		(1.6)	26%		(6.3)		
Гурил, будаа, талх	(4.6)	91%		(0.4)	9%		(5.0)	80%	
Сүү, сүүн бүтээгдэхүүн	(0.8)	42%		(1.1)	58%		(1.9)	30%	
Төрөл бүрийн өөх тос	0.8	159%		(0.3)	-59%		0.5	-8%	
Согтууруулах ундаа	(0.0)	-44%		0.0	144%		0.0	0%	
Хүнсний ногоо	(0.0)	15%		(0.0)	85%		(0.1)	1%	
Бусад	(0.1)	-87%		0.2	187%		0.1	-2%	
Бусад импорт	(9.2)	31%		(20.4)	69%		(29.6)		
Бусад	(9.2)	31%		(20.4)	69%		(29.6)	100%	
Нийт дүн	(142.5)			(37.4)			(179.9)		

Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж*/

